

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Норов	Дугаар	L281
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Их-уул сум
Төрсөн газар	Их-Уул сум	Төрсөн он	1925
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зүүн Асгатын хүрээ, Хойд Далхын хурал	Сүм хийдийн дугаар	ХӨИУ 062, ХӨИУ 063
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Зүүн Асгатын хүрээ, Хойд Далхын хурал

Мөнхбат: Тэгэхээр академич Ренчин гуайн жагсаалтанд Хөвсгөл аймгийн Их-Уул сумын нутагт Асгатын гол гэдэг газар Зүүн Асгатын хүрээ гэж нэг ийм хүрээ байжээ.Энийг бас өвгөн хүрээ ч гэж нэрлэдэг юм байна. Тэгэхээр Норов гуай та энэ одоо, Асгатын голын тэр Зүүн Асгатын хүрээ буюу Өвгөн хүрээний тухай одоо өвөг дээдсээсээ сонсож авч үлдсэн мэдээлэл бидэнд дамжуулах мэдээлэл ямар байна, энэ одоо ямархуу хэд орчим дугантай, хэд орчим лам нар хурдаг одоо ямархуу бурхан шүтээн сахиустай ийм хүрээ байсан юм бол оо?

Норов: Тэр хүрээний талаар одоо хэдэн лам хэдэн юу хүрж байсныг нь одоо тодорхой мэдэх юм байхгүй.Хамгийн сүүлд миний мэддэгээр бол Дарамжаан Дамдинжав гэдэг хүн л одоо тэр хүрээг ахалж...

Мөнхбат: Хамба нь?

Норов: Хамба нь тэрийг байсан.Тэр хүн одоо тэгээд захиргаадалтын үед болохлээр зэрэг тэрнээс хойш болоод л энд хувиараа юм үзэж хардаг, энд тэгээд нэгдүгээр сургуульд байж байгаад л нас барсан. Тэрнээс биш одоо бусад, одоо хавчиг Санжаа гэдэг хүн байсан юм гэнэ лээ. Тэр хүн бас таалал төгссөн.Одоо энэ Асгат талын ер нь

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тэрийг мэдэх талын ер нь хүн тун муу байх. Ганц наян хоёр настай Дондов гэдэг хүн байгаа.Тэр бол хуучин манай эндхийн ч хүн биш. Эрдэнэбулганаас шилжиж ирсэн хүн байгаа юм.Манай эндхийн хүргэн, тэр бол нэг их тодорхой талаар юм мэдэхгүй байх.

Мөнхбат: Тэгэхээр сумын төвөөс Асгатын хүрээ ортол, одоо энэ туурь ортол хэд орчим км байна?

Норов: За нэг хорин тав орчим л байгаа болов уу.

Мөнхбат: Энэ бол одоо яг төвөөсөө бол чанх хойшоо л гэдэг болж байна ш дээ тийм ээ, зүг нь бол?

Норов: Яг заах юм болвол чанх хойшоо.Одоо хүрээ орж байна гэхэд Цагаан бургасны даваагаар даваад л тэгээд л өгсчихнө, өөдөөгөө.

Мөнхбат: Энэ одоо хуучин энэ Их-Уул сумын нутаг, одоо яг хуучнаар Богд хаант монгол улсын үеийн ч гэдэг юм уу нөгөө Халх дөрвөн аймаг гэсэн монгол улс зохион байгуулалттай байхад ямар аймгийн, ямар хошуунд орж байсан юм бэ?

Норов: Хөвсгөл аймгийн Их-Уул суманд орж байсан. Их-Уул сумын гуравдугаар бригадад орж байсан юм аа.

Мөнхбат: Үгүй ээ, хуучин өмнөх юугаар одоо жишээ нь Засагт хан аймгийн Далай гүний хошуу ч гэдэг юм уу ингээд л явдаг ш дээ. Одоо энэ Хөвсгөл аймгийн Мөрөн энэ тэр чинь Далай гүний хошуу гээд л явдаг. Одоо жишээ нь Эрдэнэбулган сум гэхэд, одоо энэ талын Тариалан сум гэхэд Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошуу гээд л явж байгаа, жишээний. Тэгэхээр Их-Уул ямар аймгийн ямар хошуунд ордог байсан юм бол?

Норов: Их-Уул юу талдаа л орж байсан болов уу гэж бодохын би. Рашаант чинь юу гэлээ?

Мөнхбат: Мэргэн гүний хошуу.

Норов: Аа тэр Мэргэн гүний хошуунд орж байсан болов уу, Их-Уул гэж бодохын. Хэн мэдэхэв ээ, би тэр талаар худлаа хэлээд ч яахав.

Мөнхбат: За бид нар ингээд Асгатын хүрээний тухай мэдээллийг дахиад өөр дэлгэрэнгүй сайн мэдэх энэ сумын бас унаган иргэнээс авахаар ингэж шийдвэрлэлээ.Ингээд энэ Асгатын хүрээний тухай яриагаа түр орхиод ингээд энэ Хойд Далхын хурлын тухай ярилцлага хийнэ. Хойд Далхын хурлын тухай ярилцлага хийсний дараа Асгатын хүрээний туурийн тухай, түүх домгийн тухай үргэлжлүүлж ярина аа.

### Хойд Далхын хурал

Мөнхбат: За өнөөдөр 2007 оны 6 сарын 18-ны өдөр. Бид нар Хөвсгөл аймгийн Их-Уул сумын нутгаас судалгааны ажлаа үргэлжлүүлж байна аа.Ингээд Их-Уул сумын төвөөс дээш Сэлэнгэ мөрний хойд биед орших Их-Уул сумын нэгдүгээр багийн нутаг Цагаан эрэг гэдэг газар Их-Уул сумаас Мөрөн хотын явдаг төв замын урд талд дөчөөд км газарт байх энэ Хойд Далхын хурал хэмээх хурал номын газрын туурийн судалгааг үргэлжлүүлэн хийж байна. Ингээд энэ Хойд Далхын хурлын тухай ярилцахаар тус сумын өндөр настан Норов гуайтай дараах ярилцагыг үргэлжлүүлсэн юм аа.За ингээд танаас дараах хэд хэдэн асуултыг асууя, Норов гуай.Энэ ямар ч байсан Сэлэнгэ мөрөнд Хойд Далх, Өмнөд Далх гээд хоёр том хурал номын газар байж.За Өмнөд Далхын хурал бол одоогийн Рашаант сумын нутаг буюу тухайн үеийн Мэргэн гүний хошууны нутаг дэвсгэрт орж байна, тийм ээ. Аа Хойд Далхын хурал бол одоогийн энэ Их-Уул сумын нутагт байгаа энэ Цагаан

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

эрэг гэдэг газар байгаа энэ газар бол оршин тогтнож байжээ гэдэг нь бол одоо таны ярианаас бол ойлгогдох юм аа.Тэгэхээр энэ Хойд Далхын хурлын тухай та хүүхэд ахуй насандаа одоо настай хүмүүсээс өтгөс ихсээс одоо өвөг дээдсээс сонссон, нутгийн хүмүүсийн дунд ам дамжин яригдаж ирсэн тийм түүхээсээ та одоо хуучлахгүй юу?

Норов: Энэ Хойд Далхыг би одоо бүр анхан байгуулагдсанаас нь эхлээд тийм тийм лам хүрж байсан, тэр тийм үйл ажиллагаа явуулж байсан гэдгийг нь би усны урд талын хүн болохлээр тодорхой мэдэхгүй.Бага байсан, залуу байсан. Аа хойхно бол сүүлийн үед, хамгийн сүүлд энэ төр тогтнож үүсэхийн өмнөхөн талд хурлаа хүрдэг. Хамгийн сүүлд Дөшдамба, Бонхойдүвчин гэдэг хоёр хүн тэр хурлыг удирдаж тэр сүмд энэ үйл ажилагаагаа явуулж байсан.Энийг болвол би мэдэх юм.Тэгээд л тэрний үйл ажиллагаа бол тэр хоёроор л төгссөн, тэр Далх.Тэгээд л ардын хувьсгал байгуулагдсанаас хойш тэр л эрт дээр үеийн сүм хийд Далх малх чинь бол ерөөсөө яригдах юм бол шоронд орохоор байлаа ш дээ, ер нь. Тэгээд л утсан ш дээ, ерөөсөө. Тэрнээс урд бол ямар ямар лам толгойлоод анх үүсээд сууж байсныг нь бол би тодорхой мэдэхгүй.

Мөнхбат: Тэгэхээр монголын буддын шашны сүм хийдүүдийн нэг хувь заяа бий ш дээ. 37, 38, 39 оны тэр хэлмэгдүүлэлтийн их жилүүдэд лам нарыг нь баривчлаад, заримыг нь одоо хөдөө хүчээр гаргаж хар болгоод ингээд сүм хийд эзгүйрээд хэдэн жилийн дараа хоосон сүм дуган байж байснаа нутгийн ардууд буулгаад юм уу шатаагаад ингэж байсан. Зарим тохиолдолд болохоор лам нарыг нь шүүд баривчилж дунд доод лам нарыг хүчээр хөдөө гаргаж ингэж хар болгочихоод сүм дуганыг нь тэр дор нь шатааж байсан юм.Тэгэхээр энэ хоёрын аль нь энэ Далхын хурлын энд давтагдсан юм бол оо? Ямар байдлаар одоо ингэж Далхын тэр дуганыг дуусгасан бол?

Норов: Чухам Далхын дуганыг бол одоо арай шатаагаагүй байх. Би шатаасан гэж дуулаагүй.Энэ ойр нутгийн нэг хүн л авч эзэмшсэн байх. Чухам Далхад байсан тэр хурал хүрж байсан улсууд бол тэр төр тогтож үймэхэд бол тэр хоёр эндээ хоцорсон. Баригдаагүй явж байгаад л таалал төгссөн. Харин энэ Рашаантын хүрээнд сууж байсан лам нарыг бол энэ ангийн ялгаагүй цугыг нь барьж аваад...

Мөнхбат: Юу зүгээр энэ Далхын хурлыг бол түүхэнд ингэж байдаг юм.Зүгээр бид нарын үзэж судалж авсан мэдээгээр бол энэ Далхын хурал бол Рашаантын хүрээний салбар хурал байсан, салбар цагийн хурал байсан. Мэргэн гүн Гомбожав гэдэг хүний өмнөх үеийн хүн энэ Сэлэнгэ мөрний ар бие дээр энэ Сэлэнгэ мөрний ард нутагладаг зон олонд бурхны номын үйл ажиллагааг хүргэх зорилгоор энэ түр цагийн хурал бүхий хоёр дуганыг байгуулсан гэж ингэж байдаг. Энэ бол миний санаж байгаагаар 1800-аад оны сүүлч үе, бүр 1880-аад оны сүүлч 1890-ээд оны эхэн үе гэж ингэж одоо тэмдэглэгдсэн байдаг. Энэ дээр таны санал юу байна?

Норов: Тэрийг ер нь мэдэх юм байхгүй байна. Ямар ч байсан Сэлэнгийнхээ урд л нэг Далхтай , хойд талдаа нэг Далхтай л байсан.

Мөнхбат: Хоёр дуган байсан гэсэн ш дээ?

Норов: Хоёр дуган байсан. Хоёр жоохон жоохон хоёр дуган байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Тэгэхээр одоо энэ хаврын билгийн улирлын эхээр нэг лам нар гарч ирж нэг хэсэг хурдаг. За намрын хайлан цагаар гэж байгаа юм, намрын хайлнаар гэж байгаа юм. Тэр чинь одоо намар уу, намрын хайлан гэдэг чинь намрын улирлыг хэлж байгаа биз, тийм ээ. Тэр үеэр бас нэг хэсэг лам нар ирж хурдаг аа, ийм учраас тэр юу байсан, түр цагийн хуралтай байсан гэж. Тэгээд тэр Мэргэн гүний хүрээний түүхэнд бас ийм юм байгаа юм. 1937 оны эхээр Мэргэн гүний хүрээ хаагдаад, Рашаантынм хүрээ тийм , Рашаантын хүрээ хаагдаад ингэнгүүт ерөөсөө энэ Далхын хурал, Ар Далхын хурал ч, Өмнөд Далхын хурал ч түр цагийн хурал нь зогссон. Ингээд зогсмогц нь тэр Далхын хуралд байсан бурхан тахил судар номыг нь гурван тэмээнд ачаад тэгээд одоо энэ Сэлэнгэ мөрнийг гаргаж ингэж Рашаантын хүрээн дээр аваачиж тавьсан, Рашаантын хүрээн дээр. Аа тэр цагаас хойш үндсэндээ энэ хоёр дуган бүрмөсөн эзгүй болсон гэж ингэж одоо тэр түүх сударт бичсэн байх юм. Тэгэхээр энэн дээр таны санал?

Норов: Тэр ер нь үнэн л гэж бодож байна, би. Энд тэр төр үймээд л ардын засаг тогтох дээр зэрэг л ерөөсөө л бүх улсуудыг цугийг нь барьж аваад л явчихсан ш дээ, ерөөсөө. Ихэнхдээ том улсуудыг цугийг нь барьж аваад л явчихсан. Тэгээд тэр хааны ийшээ бүхын гол молд л очиж бүүдалцаан энэ тэр болж зарим нь оргож энэ тэр ирж байсан. Тэгээд тэр баригдаж явсан улсуудаас ирэх нь ирж байсан, ирээгүй нь ирээгүй тэгээд л үгүй болсон. Байхгүй, сураггүй болсон.

Мөнхбат: Та түрүүн нэг хальт хэлээд өнгөрсөн. Тэр яг энэ Далхын хүрээ мөхөхийнхөө өмнө ямар хамбатай, нэг хоёр гурван хүний нэр хэлээд өнгөрсөн. Та тэрнийгээ дахиад тодруулаад хэл дээ?

Норов. Далхын талаар ямар юм гэнэ ээ?

Мөнхбат: Нөгөө хамгийн сүүлчийн хамба, хамгийн сүүлчийн энд байсан том лам нараа та нэрийг нь хэлсэн ш дээ, түрүүн?

Норов: Аа тийм, Харин Дөшдамба, Бонхойдүвчин гэдэг хоёр хүн л хамгийн сүүлийн энэ хойд талын Цагаан эргийн Далхыг сахиж үлдэж байгаад л тэгээд л тэр хоёроор л төгссөн. Тэгээд төр үймсэн, ардын засаг тогтсон. Тэгээд тэр хоёр чинь баригдаж, барьж яваагүй. Эндээ байж байгаад л нас төгссөн.

Мөнхбат: За таньд баярлалаа. Ингээд Хөвсгөл аймгийн Их-Уул сумын нутаг дахь Хойд Далхын хурлын хоёр дуганын туурийн түүхийн тухай бид бүхэнд мэдээлэл өгсөн таньд баярлалаа. Ингээд таны өгсөн мэдээлэл монголын сүм хийдийн түүхэн товчоо судалгааны багийн мэдээлэлд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна аа. Ингээд таньд баярлалаа.